



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/13

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 12 дугаар зүйлийн 12.1, 6 дугаар зүйлийн 6.1, 16 зүйлийн 16.2, 16.2.2, Захиргааны ерөнхий хуулийн 28.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын “Дэлгэр хангай” сувиллын тусгай зөвшөөрлийн эрхийг 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн олгосугай.

2. Дээрх сувиллын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ц.Гэрэлмаад/-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын дарга бөгөөд аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА